

**ГЭМТ ЭТГЭЭД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛС ХООРОНДЫН
ГЭРЭЭ**

Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс нь, цаашид “Талууд” гэх

Бүх улс орны бүрэн эрхт байдал, эрх тэгш байдал болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх зарчмуудыг хүлээн зөвшөөрч,

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон таслан зогсоох чиглэлээрх талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэж,

Талуудын эрх зүйн тогтолцоо болон шүүх засаглалын байгууллагуудыг харилцан хүндэтгэхээ дахин нотолж,

дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөх үүрэг

Тал тус бүр шилжүүлэн өгөх гэмт хэрэгт яллах, шүүн таслах ажиллагаа явуулах, эсхүл ял оногдуулах буюу эдлүүлэхээр эрэн сурвалжилж буй Хүсэлт гаргагч Талаас шилжүүлэн өгөхийг хүссэн аливаа этгээдийг энэхүү Гэрээний заалтын дагуу нөгөө Талдаа шилжүүлэн өгөхөөр тохиролцов.

2 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх гэмт хэрэг

1. Энэхүү Гэрээний зорилгоор шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг Талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр буюу нэг (1) жилээс доошгүй хугацааны хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийг хянан шийдвэрлэх зорилгоор гаргасан бол шилжүүлэн өгч болно.

2. Талуудын дотоодын хуулийн дагуу тухайн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

а) Талуудын дотоодын хуулийн дагуу гэмт хэрэгт тооцогдох тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн ижил төрлийн ангилалд хамаарах эсэх, эсхүл ижил нэр томъёо хэрэглэж тайлбарладаг эсэх нь энэ тохиолдолд үл хамаарна;

б) Хүсэлт гаргагч Талын тайлбарласан үйлдэл нь бүхэлдээ Талуудын дотоодын хуулиар гэмт хэрэгт тооцогдож байгаа бол Талуудын дотоодын



хуульд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг ялгаатай байдлаар тодорхойлсон нь үүнд нөлөөлөхгүй.

3. Хүсэлт хүлээн авагч Талын дотоодын хуулиар ногдуулах татварын төрөл, хураамж, гаалийн төлбөрийн хувь хэмжээ, эсхүл гадаад валютын зохицуулалт нь Хүсэлт гаргагч Талынхаас өөр байна гэсэн ганцхан үндэслэлээр шилжүүлэн өгөхөөс татгалзаж болохгүй.

4. Хүсэлт хүлээн авагч Талын дотоодын хуулиар өөрийн нутаг дэвсгэрийн гадна үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгахыг хүлээн зөвшөөрдөг бол шилжүүлэн өгөхийг хүссэн гэмт хэрэг нь Хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрийн гадна үйлдэгдсэн байвал шилжүүлэхийг зөвшөөрч болно.

5. Шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь хоёр болон хэд хэдэн гэмт хэрэгт хамаарч, хэрэг тус бүр нь талуудын дотоодын хуулийн дагуу гэмт хэрэгт тооцогдох ба тэдгээрийн нэгээс доошгүй нь энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан нөхцөлүүдийг хангасан бол Хүсэлт хүлээн авагч Тал тэдгээр гэмт хэргүүдийг шилжүүлэн өгөхийг зөвшөөрч болно.

3 дугаар зүйл

Зайлшгүй татгалзах үндэслэлүүд

Дараах тохиолдолд шилжүүлэн өгөхөөс татгалзана. Үүнд:

а) Шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсан гэмт хэргийг Хүсэлт хүлээн авагч Тал улс төрийн шинжтэй гэмт хэрэг, эсхүл түүнтэй ижил төрлийн гэмт хэрэг гэж үзсэн бол. Энэхүү Гэрээний зорилгоор дараах гэмт хэргийг улс төрийн шинжтэй гэмт хэрэгт тооцохгүй. Үүнд:

i) Хүнийг алах, хүнийг алахыг завдах;

ii) Хүний амь нас, бие махбодын халдашгүй байдал, эсхүл хувь хүний эрх чөлөөнд халдсан аливаа бусад халдлага;

iii) Терроризм, эсхүл Талуудын нэгдэн орсон аливаа олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээрээр улс төрийн шинжтэй гэмт хэрэгт тооцогддоггүй өөр бусад гэмт хэрэг.

б) Хүсэлт хүлээн авагч Тал тухайн этгээдийг арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдал, иргэний харьяалал, эсхүл улс төрийн үзэл бодлынх нь төлөө мөрдөн мөшгих болон ял шийтгэл оногдуулах, мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа, эсхүл хорих ялыг эдлүүлэхдээ тэдгээрийн нөхцөл байдлыг дээрх шалтгааны улмаас дордуулахаар шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг гаргасан гэж итгэл төрөхүйц хангалттай үндэслэл байгаа бол.



с) Шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсан гэмт хэрэг нь Хүсэлт гаргагч Талд цаазаар авах ялаар, эсхүл Хүсэлт хүлээн авагч Талын дотоодын хуулиар хориглосон өөр бусад ял шийтгэл оногдуулахаар, эсхүл оногдуулсан бол.

д) Хүсэлт хүлээн авагч Талд Хүсэлт гаргагч Тал тухайн эрэн сурвалжлагдаж буй этгээдэд холбогдох хэргийг хянан шийдвэрлэж ял оногдуулахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохих журмыг хангахгүй байх, эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаан доромжлон харьцаж шийтгэсэн, эсхүл шийтгэж болзошгүй гэж итгэл төрөхүйц хангалттай үндэслэл байгаа бол.

е) Эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдийг Хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий байгууллагаас ижил гэмт хэрэгт гэм буруутайд тооцсон эсхүл цагаатгасан бол.

ф) Шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсан гэмт хэрэг Хүсэлт хүлээн авагч Талын дотоодын хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаанд заасны дагуу дуусгавар болсон, өршөөл, уучлалд хамрагдахаар бол.

г) Шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсан гэмт хэрэг нь Хүсэлт хүлээн авагч Талын дотоодын хуулийн дагуу зөвхөн цэргийн гэмт хэрэгт тооцогддог бол.

h) Хүсэлт хүлээн авагч Тал эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдэд улс төрийн орогнол олгосон бол.

i) Хүсэлт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөх нь өөрийн улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийтийн хэв журам, эсхүл бусад үндсэн эрх ашигт аюул учруулж болзошгүй гэж, эсхүл дотоодын хуульд тусгасан үндсэн зарчмуудтай зөрчилдөж болзошгүй гэж тус тус үзсэн бол.

4 дүгээр зүйл

Татгалзах нэмэлт үндэслэлүүд

Дараах аль нэг тохиолдолд шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно. Үүнд:

а) Шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсан гэмт хэрэг нь Хүсэлт хүлээн авагч Талын харьяалалд хамаарч байгаа бөгөөд Хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий байгууллага эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсантай ижил гэмт хэрэгт холбогдуулан мөрдөн шалгаж байгаа, эсхүл мөрдөн шалгагдахаар бол.

б) Хүсэлт хүлээн авагч Тал тухайн гэмт хэргийн ноцтой байдал болон Хүсэлт гаргагч Талын ашиг сонирхлыг харгалзан үзэхийн зэрэгцээ Хүсэлт хүлээн авагч Талын улсын эрүүл мэндийн эрх бүхий байгууллагаас нотолж баталгаажуулсан эрүүл мэндийн нөхцөл байдлаас шалтгаалан хүмүүнлэгийн үндэслэлээр шилжүүлэн өгөх нь зохисгүй гэж үзсэн бол.



5 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх иргэн

1. Тал бүр өөрийн улсын иргэнийг шилжүүлэн өгөхөөс татгалзах эрхтэй байна.
2. Хүсэлт хүлээн авагч Тал эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдийг иргэний харьяаллыг нь үндэслэн шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд Хүсэлт гаргагч Талын хүсэлтийн үндсэн дээр өөрийн улсын эрх бүхий байгууллагад ял шийтгүүлэхээр хэргийг шилжүүлнэ.
3. Хүсэлт хүлээн авагч Тал авсан арга хэмжээ болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнгийн талаар Хүсэлт гаргагч Талд даруй мэдээлнэ.

6 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай хүсэлт гаргах ба Эрх бүхий төв байгууллага

1. Энэхүү Гэрээний зорилгоор Монгол Улсын хувьд эрх бүхий төв байгууллагууд нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын хувьд эрх бүхий төв байгууллага нь Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхий прокурорын газар байна.
2. Эрх бүхий төв байгууллагууд нь шилжүүлэн өгөх тухай хүсэлт болон холбогдох бүхий л баримт бичгийг дипломат шугамаар дамжуулах, эсхүл шууд солилцох, тэр дундаа цахим хэрэгслээр дамжуулахаар заасан бол холбогдох Гадаад харилцааны яаманд мэдэгдэж хүргүүлнэ.
3. Тал тус бүр нь өөрийн томилсон дээр дурдсан эрх бүхий төв байгууллагад аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд энэ талаар нөгөө Талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай хүсэлт болон шаардагдах баримт бичиг

1. Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг бичгээр гаргах ба хүсэлтэд дараах зүйлийг тусгах буюу хавсаргана. Үүнд:
 - а) Хүсэлт гаргаж буй эрх бүхий байгууллагын нэр;
 - б) Эрэн сурвалжилж байгаа этгээдийн нэр, овог, төрсөн газар, огноо, хүйс, үндэс угсаа, ажил мэргэжил, оршин сууж буй эсхүл байгаа газар, таньж олох дэлгэрэнгүй мэдээлэл, мөн тухайн этгээдийг таньж олох, эсхүл байгаа газрыг



олж тогтооход тус болохуйц өөр бусад мэдээлэл, тэр дундаа хэрэв боломжтой бол цагдаагийн байгууллагын тодорхойлолт, гэрэл зураг, хурууны хээ;

с) Шилжүүлэн өгөхийг хүссэн гэмт хэргийн үйл баримтын талаарх мэдээлэл, гэмт хэрэг үйлдэгдсэн газар, огноо, түүний хуулийн зүйлчлэл;

д) Хэрэглэх хуулийн заалтуудын бичвэр, тухайлбал хүлээлгэх хариуцлага, хөөн хэлэлцэх хугацаа, оногдуулах ял шийтгэлийн талаарх хуулийн заалтууд;

е) Шилжүүлэн өгөхийг хүссэн гэмт хэрэг нь нутаг дэвсгэрийн гадна үйлдэгдсэн тохиолдолд уг гэмт хэрэг Хүсэлт гаргагч Талд харьяалагдаж буйг нотлох хуулийн заалтууд.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагаас гадна эрүүгийн хэргийг мөрдөн шалгах зорилгоор хүсэлтийг гаргасан бол Хүсэлт гаргагч Талын эрх бүхий байгууллагын баривчлах тухай шийдвэрийн хуулбарыг шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд хавсаргана.

3. Энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасны дагуу Хүсэлт гаргагч Талын гаргасан шилжүүлэн өгөх тухай хүсэлт болон түүнд хавсаргасан баримт бичгийг албажуулах, баталгаажуулах, гэрчлүүлэх, эсхүл өөр бусад шаардлага тавихгүй. Эрх бүхий төв байгууллагын албан бичиг нь дамжуулан өгч буй баримт бичгийн үнэн зөв байдлын баталгааг гаргана.

8 дугаар зүйл

Харилцах хэл

Хүсэлт гаргагч Тал шилжүүлэн өгөх тухай хүсэлт болон хүсэлтэд холбогдох бүхий л баримт бичигт Хүсэлт хүлээн авагч Талын хэлээр эсхүл англи хэлээрх орчуулгыг хавсаргана.

9 дүгээр зүйл

Нэмэлт мэдээлэл

1. Хүсэлт хүлээн авагч Тал энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгөх тухай хүсэлттэй холбогдуулан шийдвэр гаргахад Хүсэлт гаргагч Талын гаргаж өгсөн мэдээллийг хангалтгүй байна гэж үзвэл шаардлагатай нэмэлт мэдээлэл хүссэн хүсэлтийг дөчин тав (45) хоногийн дотор гаргаж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор нэмэлт мэдээллийг гаргаж өгөөгүй бол шилжүүлэн өгөх тухай хүсэлтээсээ татгалзсанд тооцно. Гэхдээ Хүсэлт гаргагч Тал тухайн этгээдийг уг хэрэгт нь холбогдуулан шилжүүлэн өгөх тухай хүсэлтээ шинээр гаргах эрхээ хадгална.



10 дугаар зүйл

Урьдчилан баривчлах

1. Хойшлуулшгүй тохиолдолд Хүсэлт гаргагч Тал эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт гаргахаас өмнө урьдчилан баривчлах тухай хүсэлтийг гаргаж болно. Урьдчилан баривчлах тухай хүсэлтийг энэхүү Гэрээнд заасан эрх бүхий төв байгууллага, Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага (ИНТЕРПОЛ), эсхүл Талуудын тохиролцсон бусад шугамаар дамжуулан гаргана.

2. Урьдчилан баривчлах тухай хүсэлтийг бичгээр гаргах ба хүсэлтэд дараах зүйлийг тусгана. Үүнд:

a) Эрэн сурвалжилж буй этгээдийн талаарх тодорхойлолт, түүний иргэний харьяаллын талаарх мэдээлэл;

b) Эрэн сурвалжилж буй этгээдийн байрлаж буй газар;

c) Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа, газар болон гэмт хэргийн үйл баримтын талаарх товч мэдэгдэл;

d) Дотоодын хуулийг зөрчсөн заалтуудын талаарх танилцуулга;

e) Эрэн сурвалжилж буй этгээдийг баривчлах тухай шийдвэр эсхүл гэм буруутай болохыг нотолсон мэдэгдэл;

f) Эрэн сурвалжилж буй тухайн этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт болон дагалдах баримт бичгийг буюу энэ зүйлийн 4 дэх хэсэгт хугацааны дотор хүргүүлэхээ илэрхийлсэн мэдэгдэл;

g) Тухайн гэмт хэрэгт оногдуулсан эсхүл оногдуулж болох ял шийтгэлийн талаарх танилцуулга.

3. Хүсэлт хүлээн авагч Тал урьдчилан баривчлах тухай хүсэлтийг хүлээн аваад эрэн сурвалжилж буй этгээдийг баривчлахтай холбогдох бүхий л шаардлагатай арга хэмжээг авч, уг хүсэлтийг хянан үзсэн шийдвэрийн дүнгийн талаар Хүсэлт гаргагч Талд даруй мэдээлнэ.

4. Хэрэв Хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий төв байгууллага энэхүү Гэрээний 7 дугаар зүйлд заасан тухайн этгээдийг цагдан хорьсноос хойш гуч (30) хоногийн дотор шилжүүлэн өгөх тухай албан ёсны хүсэлт болон хүсэлтэд холбогдох баримт бичгийг хүлээн аваагүй бол урьдчилан баривчлах ажиллагаа болон аливаа бусад албадлагын арга хэмжээг зогсооно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу урьдчилан баривчлах ажиллагааг дуусгавар болгох нь Хүсэлт хүлээн авагч Талын энэхүү Гэрээний нөхцөл болон



шаардлагын дагуу хожим хүлээн авсан эрэн сурвалжилж буй этгээдийг шилжүүлэн өгөх тухай албан ёсны хүсэлтийг үндэслэн шилжүүлэн өгөхөд саад учруулахгүй.

11 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөх тухай хэд хэдэн хүсэлт

Хүсэлт хүлээн авагч Тал тухайн нэг этгээдийг ижил гэмт хэрэгт, эсхүл өөр гэмт хэрэгт холбогдуулан шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг Хүсэлт гаргагч Талаас гадна нэг, эсхүл өөр хэд хэдэн гуравдагч улсаас хүлээн авсан бол холбогдох бүхий л хүчин зүйлийг, тухайлбал дор дурдсаныг харгалзан үзсэний үндсэн дээр аль улсад шилжүүлэн өгөхөө тодорхойлно. Үүнд:

- a) Шилжүүлэн өгөх тухай хүсэлтүүдэд өөр өөр гэмт хэргийн талаар дурдсан бол тухайн гэмт хэргүүдийн ноцтой байдлын талаар;
- b) Гэмт хэрэг тус бүрийн үйлдэгдсэн цаг хугацаа, газар;
- c) Хүсэлтүүдийн огноо;
- d) Эрэн сурвалжилж буй этгээдийн үндэс угсаа;
- e) Эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдийн байнгын оршин суугаа газар;
- f) Хүсэлтүүдийг энэхүү Гэрээний дагуу, эсхүл шилжүүлэн өгөх тухай өөр хэлэлцээрийн дагуу гаргасан эсэх, түүний холбогдох заалтуудыг авч үзэх;
- g) Холбогдох улсуудын эрх ашиг;
- h) Хохирогч (хохирогчдын)-ийн үндэс угсаа;
- i) Шилжүүлэн өгсөн тухайн этгээдийг гуравдагч улсад дараа нь шилжүүлэн өгөх боломж.

12 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай шийдвэр

1. Хүсэлт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөх тухай шийдвэрээ дотоодын хууль тогтоомжид заасан журмын дагуу гаргах бөгөөд гаргасан шийдвэрийнхээ талаар Хүсэлт гаргагч талд даруй мэдээлнэ.

2. Хэрэв Хүсэлт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөх тухай хүсэлтээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзаж шийдвэрлэсэн бол ийнхүү татгалзсан шалтгааны талаар Хүсэлт гаргагч талд мэдээлнэ.



13 дугаар зүйл

Шилжүүлэн өгч буй этгээдийг хүлээлгэн өгөх

1. Хэрэв Хүсэлт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэвэл Талууд эрэн сурвалжилж буй тухайн этгээдийг хүлээлгэн өгөх цаг, газар болон холбогдох бусад зохион байгуулалтын талаар нэн даруй тохиролцоно. Хүсэлт гаргагч Талд шилжүүлэн өгөх этгээдийг цагдан хорьсон хугацааны талаар мэдээлнэ.

2. Хүсэлт гаргагч Талд шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн болохыг мэдэгдсэнээс хойш гуч (30) хоногийн дотор эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдийг шилжүүлнэ.

3. Хэрэв Хүсэлт гаргагч Тал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааны дотор тухайн этгээдийг шилжүүлэн аваагүй бол Хүсэлт хүлээн авагч Тал тухайн этгээдийг тэр даруй суллаж, энэ зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд ижил гэмт хэргээр шилжүүлэн өгөх тухай дараагийн хүсэлтээс татгалзаж болно.

4. Хэрэв аль нэг Тал тухайн этгээдийг Талуудын тохирсон хугацааны дотор өөрөөс үл хамаарах шалтгаан буюу давагдашгүй хүчин зүйл болон бусад нөхцөл байдлын улмаас хүлээлгэн өгөх, хүлээн авах боломжгүй нөхцөл байдал үүсвэл холбогдох Тал энэ талаар нөгөө Талдаа мэдэгдэнэ. Ийнхүү хүлээлгэн өгөх, хүлээн авах боломжгүйд хүргэсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд Талууд шилжүүлэх хугацааг шинээр тохиролцоно. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан журам шинээр тохиролцсон хугацаанд мөн адил хамаарна.


5. Хэрэв шилжүүлэн өгсөн этгээдийг Хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрт ял эдлүүлэх, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусахаас өмнө Хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт буцаавал тухайн этгээдийг ижил гэмт хэрэгт холбогдуулан шилжүүлэн өгөх тухай шинээр гаргасан хүсэлтэд үндэслэн дахин шилжүүлэн өгч болно. Энэ тохиолдолд Хүсэлт гаргагч Талаас энэхүү Гэрээний 7 дугаар зүйлд заасан баримт бичгийг ирүүлэхийг шаардахгүй.

6. Хүсэлт гаргагч Тал баривчлагдсан өдрөөс хойш шилжүүлэн өгөх хүртэлх цагдан хоригдсон хугацааг цагдан хоригдсон эсхүл эдлэх ялын хугацаанд оруулан тооцно.

14 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хойшлуулах болон Түр хугацаанд хүлээлгэн өгөх

1. Эрэн сурвалжилж буй этгээд нь шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсанаас өөр гэмт хэрэгт Хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл ял эдэлж байгаа бол Хүсэлт хүлээн авагч Тал тухайн этгээдийг түр хугацаанд



хүлээлгэн өгөх, эсхүл түүнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусах хүртэл, эсхүл түүнд оногдуулсан ялыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн эдлүүлэх хүртэлх хугацаанд хойшлуулж болно. Хүсэлт хүлээн авагч Тал хойшлуулж байгаа талаар Хүсэлт гаргагч Талд мэдээлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлөөс гадна эрэн сурвалжилж буй этгээдийн эрүүл мэндийн байдал нь түүний амь насанд аюул учруулахаар, эсхүл илтэд доройтуулахаар эрсдэлтэй бол шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно. Эдгээр тохиолдолд Хүсэлт хүлээн авагч Талаас өөрийн эрүүл мэндийн төрийн аль нэг байгууллагаас гаргасан эрүүл мэндийн дэлгэрэнгүй дүгнэлтийг Хүсэлт гаргагч Талд хүргүүлнэ.

3. Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг шилжүүлэн өгөх боломжтой гэж үзвэл дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрсөн хүрээнд Талуудын тохиролцсон нөхцөлөөр Хүсэлт хүлээн авагч Тал тухайн этгээдийг мөрдөн шалгуулахаар Хүсэлт гаргагч Талд түр хугацаанд хүлээлгэн өгч болно. Хүсэлт гаргагч Тал нутаг дэвсгэртээ түр хугацаанд хүлээлгэн өгсөн этгээдийг цагдан хорих бөгөөд хянан шийдвэрлэх ажиллагаа дуусмагц Хүсэлт хүлээн авагч Талд буцаан хүлээлгэн өгнө. Эцэст нь тухайн этгээдэд оногдуулсан аливаа ялыг эдлүүлэхээр энэхүү Гэрээний заалтын дагуу Хүсэлт гаргагч Талд бүрмөсөн хүлээлгэн өгнө.

15 дугаар зүйл

Онцгой журам

1. Энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгсөн этгээдийг дор дурдсанаас бусад тохиолдолд шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн аливаа гэмт хэргийнх нь төлөө, шилжүүлэн өгснөөс өөр гэмт хэрэгт холбогдуулан мөрдөн шалгах, шүүх, хорих, эсхүл эрх чөлөөг нь хязгаарласан аливаа арга хэмжээ авахыг хориглоно. Үүнд:

а) Шилжүүлэн өгсөн этгээд Хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрийг орхин явж, сайн дурын үндсэн дээр буцаж ирсэн бол;

б) Шилжүүлэн өгсөн этгээд боломжтой байсан боловч Хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрийг дөчин тав (45) хоногийн дотор орхин явж чадаагүй бол. Энэхүү хугацаанд тухайн этгээдийн өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас орхин гарч чадаагүй хугацааг оруулахгүй;

с) Хүсэлт хүлээн авагч Тал уг яллах ажиллагааг зөвшөөрсөн. Эдгээр тохиолдолд Хүсэлт хүлээн авагч Тал энэхүү Гэрээний 7 дугаар зүйлд заасан баримт бичиг болон мэдээллийг ирүүлэхийг хүсэж болно.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн зүйлчлэл, эсхүл үйл баримтаас хамааран оногдуулах ял шийтгэл нь өөрчлөгдсөн бол шилжүүлэн өгсөн этгээдийг энэхүү Гэрээний дагуу шилжүүлж болох тухайн шинэ гэмт хэрэгт нь мөрдөн шалгаж болно.



16 дугаар зүйл

Гуравдагч улсад дахин шилжүүлэн өгөх

1. Энэхүү гэрээний 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a) болон (b)-д зааснаас бусад тохиолдолд Хүсэлт гаргагч Тал тухайн этгээдийг Хүсэлт хүлээн авагч Талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч улсад шилжүүлэн өгөхгүй.

2. Хүсэлт хүлээн авагч Тал энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрөл хүссэн аливаа хүсэлттэй холбогдуулан гуравдагч улсаас хүргүүлсэн баримт бичгийг ирүүлэхийг Хүсэлт гаргагч талаас шаардаж болно.

17 дугаар зүйл

Эд зүйл болон эд хөрөнгө хүлээлгэн өгөх

1. Хүсэлт гаргагч Талаас хүсэлтийг хүлээн авмагцаа Хүсэлт хүлээн авагч Талын өөрийн нутаг дэвсгэр дээр эрэн сурвалжлагдаж буй этгээдийн эзэмшлийн болох нь тогтоогдсон эд зүйлсийг дотоодын хууль тогтоомжийн дагуу хураан авна. Хүсэлт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд тэдгээр эд зүйлийг Хүсэлт гаргагч Талд шилжүүлнэ. Энэ зүйлийн зорилгоор дор дурдсан зүйлийг хураан авч, Хүсэлт гаргагч Талд дараа нь шилжүүлнэ. Үүнд:

а) Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан нотлох баримтын шинжтэй эд зүйл, хэрэгсэл;

б) Эрэн сурвалжлагдаж буй этгээдийн эзэмшлийн болох нь тогтоогдсон эд зүйлс, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон болох нь хожим тогтоогдсон шууд болон шууд бус орлого;

с) Гэмт хэргээс олсон шууд болон шууд бус орлого гэж үзэх үндэслэлтэй эд хөрөнгө болон мөнгөн хөрөнгө.

2. Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн боловч эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээд нас барсан, сураггүй алга болсон, эсхүл оргон зайлсны улмаас хүсэлтийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд зүйл болон, эсхүл эд хөрөнгийг шилжүүлнэ.

3. Хүсэлт хүлээн авагч Тал өөрийн явуулж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах зорилгоор тухайн эд зүйл болон, эсхүл эд хөрөнгийг шилжүүлэхийг хойшлуулах, эсхүл Хүсэлт гаргагч тал буцаан шилжүүлэхээ илэрхийлсэн нөхцөлд түр хугацаагаар шилжүүлж болно.

4. Эд зүйл болон, эсхүл эд хөрөнгийг шилжүүлэх нь Хүсэлт хүлээн авагч Талын, эсхүл шударга аливаа гуравдагч этгээдийн хууль ёсны эрх болон ашиг



сонирхолд хохирол учруулахгүй. Хэрэв хууль ёсны эрх болон ашиг сонирхол байгаа бол шилжүүлсэн эд зүйл болон, эсхүл эд хөрөнгийг Хүсэлт гаргагч Тал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссаны дараа Хүсэлт хүлээн авагч Талд, эсхүл шударга гуравдагч этгээдэд аливаа төлбөргүйгээр, хойшлуулалгүйгээр буцаан шилжүүлнэ.

18 дугаар зүйл

Дамжин өнгөрөх

1. Тал тус бүр нь (цаашид “дамжин өнгөрүүлж буй Тал” гэх) дамжин өнгөрүүлэхэд нийтийн ашиг сонирхолд саад учруулахааргүй бол энэ зүйлд заасны дагуу гуравдагч улсаас нөгөө Талд (Хүсэлт гаргагч Тал) шилжүүлэн өгч буй этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхийг зөвшөөрч болно.

2. Хүсэлт гаргагч Тал дамжин өнгөрөх тухай хүсэлтийг эрх бүхий төв байгууллагаар, эсхүл яаралтай тохиолдолд Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага (ИНТЕРПОЛ)-аар дамжуулан гаргана. Энэхүү хүсэлтэд дамжин өнгөрөх тухайн этгээдийн хувийн дэлгэрэнгүй мэдээлэл болон хэргийн үйл баримтын талаарх товч мэдээллийг тусгана. Хүсэлт гаргагч Талын шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн гуравдагч улсын шийдвэрийн хуулбарыг энэхүү дамжин өнгөрөх тухай хүсэлтэд хавсаргана.

3. Дамжин өнгөрүүлж буй Тал өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй тухайн этгээдийг нутаг дэвсгэртээ байх хугацаанд нь саатуулна.

4. Агаарын тээвэр ашиглаж байгаа болон дамжин өнгөрүүлж буй Талын нутаг дэвсгэрт буулт хийхгүй бол дамжин өнгөрөх зөвшөөрлийг шаардахгүй. Хэрэв дамжин өнгөрүүлж буй Талын нутаг дэвсгэрт төлөвлөгдөөгүй буулт хийх тохиолдолд Хүсэлт гаргагч Тал нутаг дэвсгэрээрээ дамжин өнгөрүүлж буй Талд энэ талаар нэн даруй мэдээлэх ба дамжин өнгөрүүлж буй Тал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан дамжин өнгөрөх тухай албан ёсны хүсэлтийг хүлээн авах хүртэл дамжин өнгөрч буй тухайн этгээдийг ерэн зургаа (96) цаг хүртэлх хугацаагаар саатуулна.

19 дүгээр зүйл

Зардал

1. Хүсэлт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг гүйцэтгэхтэй холбогдуулан бүхий л шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба түүнтэй холбогдох зардлыг хариуцна.

2. Хүсэлт хүлээн авагч Тал эрэн сурвалжлагдаж буй этгээдийг Хүсэлт гаргагч Талд шилжүүлэн өгөх хүртэл нутаг дэвсгэр дээрээ баривчлах, цагдан хорихтой холбогдон гарах зардлыг, түүнчлэн энэхүү Гэрээний 17 дугаар зүйлд заасан эд зүйл



болон, эсхүл эд хөрөнгийг хураан авах, хадгалахтай холбогдон гарах зардлыг хариуцна.

3. Хүсэлт гаргагч Тал шилжүүлэн өгөх этгээд болон хураан авсан аливаа эд зүйл болон, эсхүл мөнгөн хөрөнгийг Хүсэлт хүлээн авагч Тал хүртэл тээвэрлэхтэй холбогдон гарах зардал, түүнчлэн энэхүү Гэрээний 18 дугаар зүйлд заасан дамжин өнгөрөхтэй холбогдон гарах зардлыг хариуцна.

20 дугаар зүйл

Хүлээлгэн өгсний дараах мэдээлэл

Хүсэлт хүлээн авагч Талын хүсэлтийн дагуу Хүсэлт гаргагч Тал шилжүүлэн өгсөн этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон түүнд оногдуулсан ял шийтгэлийн гүйцэтгэлийн талаарх, эсхүл тухайн этгээдийг гуравдагч улсад шилжүүлэн өгөхтэй холбогдох аливаа мэдээллийг нэн даруй гаргаж өгнө.

21 дүгээр зүйл

Олон улсын бусад гэрээтэй холбогдох нь

Энэхүү Гэрээ нь талуудын нэгдэн орсон олон улсын бусад гэрээний дагуу аль нэг Тал нөгөө Талтай шилжүүлэн өгөх асуудлаар хамтран ажиллахад саад болохгүй.

22 дугаар зүйл

Нууцлал

1. Талууд шилжүүлэн өгөх ажиллагаанд ашигласан аливаа баримт бичиг болон мэдээлэл, түүнчлэн шилжүүлэн өгөх тухайн этгээдийг хүлээлгэн өгсний дараа олж авсан холбогдох аливаа мэдээллийн нууцлалыг хадгалахаар тохиролцов.

2. Тал тус бүр нөгөө Талын тавьсан шаардлагын дагуу хүлээн авсан, эсхүл хүлээлгэн өгсөн аливаа баримт бичиг болон мэдээллийн нууцлалыг хүндэтгэж, аюулгүй байдлыг хамгаалах үүргийг хүлээнэ.

3. Тал тус бүр мэдээллийг алдах, зөвшөөрөлгүй танилцах, ашиглах, өөрчлөх, задруулах, урвуулан ашиглахаас хамгаалах үүргийг хүлээнэ.



23 дугаар зүйл

Хувийн мэдээллийг хамгаалах

1. Энэ зүйлийн 2 дахь заалтыг хөндөхгүйгээр, зөвхөн шаардлагатай тохиолдолд хувийн мэдээллийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсан зорилгод нийцүүлэн цуглуулж, шилжүүлж болно.

2. Энэхүү гэрээний дагуу нэг Талаас нөгөө Талд шилжүүлэн өгөх тухай хүсэлтийн нэг хэсэг болгон шилжүүлсэн хувийн мэдээллийг хүлээн авсан Тал зөвхөн дараахь тохиолдолд ашиглаж болно. Үүнд:

а) Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийн хүрээнд явуулж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан;

б) (а)-д дурдсантай шууд холбогдох бусад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан;

с) Олон нийтийн аюулгүй байдалд шууд бөгөөд ноцтой аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор.

3. Мэдээллийг гаргаж өгсөн Талаас урьдчилан зөвшөөрлийг авсны үндсэн дээр тухайн мэдээллийг өөр бусад зорилгоор ашиглаж болно.

4. Аль нэг Тал нь дотоодын хууль тогтоомжийн дагуу хувийн мэдээллийг хамгаалдаг бөгөөд нөгөө Тал тухайн түвшинд нь хамгаалж чадахгүй бол уг мэдээллийг шилжүүлэхээс татгалзаж болно.

5. Мэдээллийг шилжүүлж буй Тал тухайн мэдээллийг хэрхэн ашиглах талаар мэдээлэл ирүүлэхийг хүлээн авч буй Талаас хүсэж болно.

6. Энэхүү Гэрээний дагуу шилжүүлсэн хувийн мэдээллийг хүлээн авсан Тал дотоодын хууль тогтоомжийн дагуу ашиглаж, устгана.

7. Энэ зүйл нь мэдээллийг шилжүүлж буй Талын тохиолдол тус бүрээр нь нэмэлт нөхцөл тавих эрхийг хязгаарлахгүй. Нэмэлт нөхцөл тавьсан тохиолдолд мэдээллийг хүлээн авч буй Тал тавьсан нөхцөлийн дагуу ашиглана.

24 дүгээр зүйл

Зөвлөлдөх болон маргаан шийдвэрлэх

1. Эрх бүхий төв байгууллагууд энэхүү Гэрээг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбогдох, эсхүл шилжүүлэн өгөх тухай тодорхой хүсэлтээр өөр хоорондоо харилцан зөвлөлдөнө.



2. Энэхүү Гэрээг тайлбарлах болон хэрэглэхтэй холбогдон гарах аливаа маргааныг Талууд шууд зөвлөлдөх болон хэлэлцээ хийх замаар, эсхүл дипломат шугамаар эвийн журмаар шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох, нэмэлт өөрчлөлт оруулах болон дуусгавар болгох

1. Энэхүү Гэрээ Талуудын гэрээг хүчин төгөлдөр болгохтой холбоотой дотоодын хуулийн шаардлагаа хангасан болохыг баталгаажуулан бичгээр харилцан бие биедээ дипломат шугамаар мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Талуудын харилцан зөвшөөрснөөр энэхүү Гэрээнд тусдаа протоколоор өөрчлөлт эсхүл нэмэлт оруулж болох ба энэ нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасантай адил журмын дагуу хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү Гэрээг хугацаагүйгээр байгуулсан болно. Аль нэг Тал нөгөө Талдаа бичгээр дипломат шугамаар мэдэгдсэнээр энэхүү Гэрээг дуусгавар болгож болно. Энэ тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 180 хоногийн дараа Гэрээ хүчингүй болно. Талууд бичгээр тохиролцоогүй бол энэхүү Гэрээг дуусгавар болгох нь Талуудын гэрээг дуусгавар болгохоос өмнө эхлүүлсэн шилжүүлэн өгөх ажиллагаанд нөлөөлөхгүй.

4. Энэхүү Гэрээ нь гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдэгдсэн гэмт хэргийг гэрээ хүчин төгөлдөр болсны дараа шилжүүлэхээр гаргасан хүсэлтэд хамаарна.

Дээр дурдсаныг нотлон Талуудын зохих ёсоор эрх нь олгогдсон бүрэн эрхт төлөөлөгчид энэхүү Гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү Гэрээг хотноо оны дугаар сарын -ны өдөр монгол, киргиз, орос болон англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлах үед зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ**

